



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар

764

Мандалговь

Г М.Золбоог Гэр бүл, хүүхэд, залуучуудын Г
хөгжлийн газрын Хууль, эрх зүй, хамтын ажиллагаа
хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хууль, эрх зүй, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Мөнхцэгмэд овогтой Золбоо 77.6 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа М.Золбоогийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын
14-ны өдрийн 14 дугаар тогтоолын хавсралт



**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
Хууль, эрх зүй, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлсэн М.Золбоогийн тухай дүгнэлт**

1. М.Золбоо нь 2000 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрсөн. 23 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2018-2022 онд Их засаг Их сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.
3. М.Золбоогийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хууль, эрх зүй, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ